



## Тэмдэгтийг форматлах

Та хүснэгт байгуулах явцдаа олон янзын үсгийн фонт, хэмжээ, хэлбэр болон өнгийг хэрэглэх боломжтой. Excel-ийн байнгын стандарт фонт нь англи үсгийн фонт байдаг тул англиар бичих хэрэгтэй бол текстээ нүдэнд шууд оруулж болно. Харин нүдэнд монгол текст оруулах үед монгол үсгийн горим руу шилжих хэрэгтэй.

### Үсгийн фонт сонгох

Үсгийн фонт болон түүний хэлбэр, өнгө зэрэг форматыг командыг хэрэгслийн самбар дээрх Font бүлэг доторх товчнуудаар өөрчилж болно.

|                                                                                     |                                                |
|-------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------|
| Times New Rom ▾                                                                     | Үсэг, тэмдэгтийн шрифт буюу фонтыг өөрчилнө.   |
| 11 ▾                                                                                | Үсэг, тэмдэгтийн хэмжээг өөрчилнө.             |
| A <sup>+</sup> A <sup>-</sup>                                                       | Үсэг, тэмдэгтийн хэмжээг томруулж, жижигсгэнэ. |
| <b>B</b>                                                                            | Үсэг, тэмдэгтийг тодруулна.                    |
| <i>I</i>                                                                            | Үсэг, тэмдэгтийг налуу болгоно.                |
| <u>U</u> ▾                                                                          | Үсэг, тэмдэгтийн доогуур зураас оруулна        |
|  ▾ | Нүдэнд хүрээ оруулна                           |
|  ▾ | Нүдэнд дэвсгэр фон оруулна.                    |
| <b>A</b> ▾                                                                          | Үсэг, тэмдэгтийн өнгийг өөрчилнө.              |

Хэрэв та ямар нэг үсгийн фонт ямархуу хэлбэртэй болохыг тухайн фонтыг сонгохоосоо өмнө урьдчилан харахыг хүсвэл Font бүлгийн баруун доод буланд байгаа сумтай товчин дээр дарж харилцах цонхыг нээгээд дараа нь фонтыг сонгоорой. Тухайн фонтын хэлбэр нь харилцах цонхны Preview хэсэгт харагдана.

### Excel-ийн стандарт фонтыг солих

Та өөрийн байнга хэрэглэдэг үсгийн фонтоо Excel-ийг ажиллуулах болгонд автоматаар гарч ирдэг стандарт фонт болгож, хүснэгт байгуулах болгондоо фонт сонгодог ажиллагаагаа хялбарчлах боломжтой.

#### *Excel-ийн стандарт фонтыг өөр фонтоор солихдоо:*

1. MS Office-ийн товчин дээр дарна.
2. Excel Options нэртэй товчин дээр дарна.
3. Popular төрлийг сонгож дарна.
4. Баруун талын самбар дээрх When Creating new workbook хэсгийн Use this font дотроос байнга стандарт фонт болгохыг хүсэж байгаа фонтоо сонгоно. Дараа нь Font size дотор хэмжээг нь сонгоно.
5. ОК дарна.
6. Сонгосон фонтыг стандарт фонт болгохын тулд Excel-ээс гараад дахин шинээр эхлүүлэхийг мэдэгдсэн цонх гарч ирнэ. Та энэ цонхны ОК командыг товчин дээр дарна.
7. Программын цонхны  товчин дээр дарж Excel-ээс гарна.
8. Excel 2007 программыг дахин эхлүүлж сонгосон фонт, хэмжээ сонгогдсон байгааг харж болно.